

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/021/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaa.e@audit.gov.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолал, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 24 № 90

танай _____ -ны № _____ -т

ДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.СҮХБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, эмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс төрийн албан хаагч, малчдад зөвлөгөөн, сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах, хүндэтгэл үзүүлэхэд 8,463.2 мянган төгрөгийг зарцуулсан;
- Үнэ төлбөргүй ирсэн 109,400.0 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй,

8225020230

- Ажиллагсдын цалингийн урьдчилгаа 1,930.0 мянган төгрөгийг суутгаагүй, цалин, урамшуулалд 917.2 мянган төгрөгийг илүү олгосон, захирамж 600.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 1,073.0 мянган төгрөгийг, анхан шатны баримтгүй 320.0 мянган төгрөгийн албан томилолтыг олгосон;
- Сумын 100 жилийн ойн дэмжлэгийг баярын хүлээн авалт, бэлэг дурсгалын хүнсний материал худалдан авч хоол бэлтгэхэд, үзэсгэлэнт газрын зураг авалт, үзэсгэлэнгийн зураг, сумын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хөгжил дэвшил ном товхимол хэвлэлт, бусад урсгал зардал, ажлын хөлс олгосон зэрэгт 90,451.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиож аймгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос 85,329.0 мянган төгрөгөөр дэмжлэгийг баярын хүлээн авалт, бэлэг дурсгалын хүнсний материал худалдан авч хоол, үзэсгэлэнт газрын зураг авалт, үзэсгэлэнгийн зураг, сумын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хөгжил дэвшил ном товхимол хэвлэлт, бусад урсгал зардал, ажлын хөлсөнд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгөнд Онцгой байдлын ерөнхий газраас 106,900.0 мянган төгрөгийн үнэ бүхий Jemnin маркийн 63-66 ГАУ дугаартай авто тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч, Алтай хотын тохижилт үйлчилгээний газраас 2,500.0 мянган төгрөгийн чиргүүл шилжиж ирсэн, Байгаль орчны газраас 14,547.7 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-аас 25,000.0 мянган төгрөгийн, сумын ОНХС-аас 117,900.0 мянган төгрөгийн, сумын 100 жилийн ойн хандиваар 215,850.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 785,613.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс 30,267.1 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 167 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас хэрэгжилтийг тайлагнаж сумын Засаг даргын нийт дүнгээр 88.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	155,167,448.98	149,892,459.96
33	АВЛАГА	70,895,355.13	62,450,366.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	383,508.20	383,508.20
335	Бусад авлага	70,511,846.93	62,066,858.56
3351	Байгууллагаас авах авлага	21,885,676.93	13,440,688.56
3352	Хувь хүмүүсээс авах авлага	48,626,170.00	48,626,170.00
35	БАРАА МАТЕРИАЛ	84,272,093.85	87,442,093.20
354	Хангамжийн материал	9,362,093.85	12,532,093.20
35410	Бичиг хэргийн материал	149,775.00	149,775.00
35420	Аж ахуйн материал	9,212,318.20	12,382,318.20
35440	Түлш, шатах тослох материал	0.65	-
35600	Мал амьтад	74,910,000.00	74,910,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,774,255,714.44	5,021,532,410.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,774,255,714.44	5,021,532,410.87
392	Биет хөрөнгө	3,227,609,114.44	3,474,885,810.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,510,632,989.43	2,480,187,461.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(217,240,206.68)	(297,814,940.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	195,538,172.00	249,838,172.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(120,439,663.35)	(97,061,296.87)
39205	Машин тонг төхөөрөмж (компьютер)	402,326,649.00	432,517,745.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(302,857,486.99)	(336,066,960.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,280,300.97	194,130,300.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(78,389,187.23)	(91,134,733.61)
39209	Зам, гүүрийн байгууламж	213,000,000.00	213,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,508,333.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	675,002,036.63	944,449,796.63
39215	Хуримтлагдсан элэгдэл	(166,473,723.34)	(213,880,634.67)
39217	Ном	3,229,234.00	3,229,234.00
393	Биет бус хөрөнгө	1,546,646,600.00	1,546,646,600.00
39301	Програм хангамж	1,740,000.00	1,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,740,000.00)	(1,740,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,546,646,600.00	1,546,646,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,929,423,163.42	5,171,424,870.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,749,015.00	75,585,866.71
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,749,015.00	75,585,866.71
413	Өглөг	14,749,015.00	75,585,866.71
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	27,000.00	46,450,078.51
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,609,850.00	7,392,623.20
4136	Бусад өглөг	10,112,165.00	21,743,165.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,112,165.00	21,743,165.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,914,674,148.42	5,095,839,004.12
51	Засгийн газрын хувь оролцоо	4,914,674,148.42	5,095,839,004.12
511	Засгийн газрын озуулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	626,748,340.32	626,748,340.32
51101	Өмч: - төрийн	626,748,340.32	626,748,340.32
512	Хуримтлагдсан үр дүн	3,758,520,515.23	3,939,685,370.93
51210	Өмнөх үеийн үр дүн	3,758,520,515.23	3,758,520,515.23
51220	Тайлант үеийн үр дүн		181,164,855.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	529,405,292.87	529,405,292.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,929,423,163.42	5,171,424,870.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,335,415,462.00	1,375,875,159.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,472,851,516.00	456,864,426.66
120	Нийтлэг татварын бус орлого	3,472,851,516.00	456,864,426.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,472,851,516.00	456,864,426.66
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,472,851,516.00	456,864,426.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	862,563,946.00	919,010,733.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	243,241,346.00	163,664,033.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,241,346.00	163,664,033.00
1320	Орон нутгийн төсөөс санхүүжих	619,322,600.00	755,346,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	619,322,600.00	755,346,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	692,685,032.95	1,161,349,594.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,685,032.95	1,063,203,259.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,648,058.00	1,015,893,978.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,112,051.02	575,733,730.65
210101	Үндсэн цалин	218,539,922.06	336,837,216.87
210102	Нэмэгдэл	98,554,727.25	227,654,801.50
210104	Урамшуулал	24,017,401.71	11,241,712.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,919,069.07	77,551,071.46
210201	Тэтгэврийн даатгал	33,611,002.36	58,263,674.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,107,412.59	4,821,299.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,685,963.13	2,411,199.21
210204	Ажилгүйдлийн даатгал	408,906.19	2,411,199.35
210205	Эрүүл мэндийн даатгал	5,105,784.80	9,643,699.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,886,727.53	45,897,960.80
210301	Гэрэл, цахилгаан	6,403,447.53	6,630,716.00
210302	Түлш, халаалт	20,483,280.00	39,267,244.80
2104	Хангамж, бараа материалын зардал	40,774,782.00	48,208,981.85
210401	Бичиг хэрэг	4,195,600.00	5,722,400.00
210402	Тээвэр, шатахуун	32,621,385.00	39,622,448.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,385,947.00	2,044,033.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,571,850.00	820,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,189,400.00	3,002,400.00
210604	Урсгал засвар	5,189,400.00	3,002,400.00
2107	Томилолт, зочны зардал	5,160,137.00	4,504,217.00
210702	Дотоод албан томилолт	5,160,137.00	4,504,217.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,872,450.00	38,049,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,908,000.00	37,146,250.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	462,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	560,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,706,441.38	222,946,616.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,172,000.00	14,259,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	278,800.00	269,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,255,641.38	208,418,116.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,036,974.95	47,309,280.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,650,449.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	35,614,449.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,036,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,036,974.95	9,658,831.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,036,974.95	9,658,831.97
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		98,146,335.00
2200	Дотоод эх үүсвэрээр		98,146,335.00
223001	Бусад хөрөнгө		98,146,335.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,642,757,429.05	214,525,564.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	37,559,800.00	33,360,709.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	37,559,800.00	33,360,709.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-37,559,800.00	-33,360,709.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,605,170,549.05	181,164,855.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	865,063,946.00	936,010,733.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	865,063,946.00	936,010,733.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,741,346.00	180,664,033.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	245,741,346.00	180,664,033.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	619,322,600.00	755,346,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	619,322,600.00	755,346,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	557,438,826.00	798,274,302.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557,438,826.00	798,274,302.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,476,085.62	742,410,009.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,701,624.02	546,590,526.65
210101	Үндсэн цалин	223,539,922.06	307,694,012.87
210102	Нэмэгдэл	103,144,300.25	227,654,801.50
210104	Урамшуулал	24,017,401.71	11,241,712.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,086,766.07	60,271,196.95
210201	Тэтгэврийн даатгал	35,778,699.36	40,983,799.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,107,412.59	4,821,299.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,685,963.13	2,411,199.21
210204	Ажилгүйдлийн даатгал	408,906.19	2,411,199.35
210205	Эрүүл мэндийн даатгал	5,105,784.80	9,643,699.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,886,727.53	41,766,960.80
210301	Гэрэл, цахилгаан	6,403,447.53	6,630,716.00
210302	Түлш, халаалт	20,483,280.00	35,136,244.80
2104	Хангамж, бараа материалын зардал	36,319,181.00	44,456,333.00
210401	Бичиг хэрэг	4,536,600.00	5,722,400.00
210402	Тээвэр, шатахуун	28,010,934.00	35,869,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,385,947.00	2,044,033.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,385,700.00	820,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,987,400.00	3,002,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	4,987,400.00	3,002,400.00
2107	Томилолт, зочны зардал	5,160,137.00	4,504,217.00
210702	Дотоод албан томилолт	5,160,137.00	4,504,217.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,653,450.00	27,289,875.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,689,000.00	26,387,125.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	462,750.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	560,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,680,800.00	14,528,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,172,000.00	14,259,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	508,800.00	269,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,962,740.38	55,864,292.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	37,650,449.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	35,614,449.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,036,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,962,740.38	18,213,843.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,036,974.95	9,658,831.97
213403	Хөрөнгийн	20,925,765.43	8,555,011.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	307,625,120.00	137,736,431.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	307,625,120.00	137,736,431.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	307,625,120.00	137,736,431.00
2200	Дотоод эх үүсвэрээр	307,625,120.00	137,736,431.00
223001	Бусад хөрөнгө	41,484,466.00	105,545,335.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	266,140,654.00	32,191,096.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-307,625,120.00	-137,736,431.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	153,349,966.18	1,309,503,599.37
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	153,349,966.18	1,309,503,599.37
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,605,170,549.05	3,605,170,549.05
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,758,520,515.23	4,914,674,148.42
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,758,520,515.23	4,914,674,148.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(27,000.00)	(27,000.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,758,520,515.23	4,914,674,148.42
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	181,164,855.70	181,164,855.70
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	626,748,340.32	529,405,292.87	3,939,685,370.93	5,095,839,004.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	785,613,800.00	745,687,868.03	39,925,931.97	94.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	780,341,800.00	740,454,953.03	39,886,846.97	94.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	741,601,800.00	702,804,504.03	38,797,295.97	94.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567,700,000.00	546,590,526.65	21,109,473.35	96.28
210101	Үндсэн цалин	187,700,000.00	307,694,012.87	-119,994,012.87	163.93
210102	Нэмэгдэл	380,000,000.00	227,654,801.50	152,345,198.50	59.91
210104	Урамшуулал	-	11,241,712.28	-11,241,712.28	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,950,000.00	60,271,196.95	5,678,803.05	91.39
210201	Тэтгэврийн даатгал	44,910,000.00	40,983,799.57	3,926,200.43	91.26
210202	Тэтгэмжийн даатгал	5,260,000.00	4,821,299.42	438,700.58	91.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,208,000.00	2,411,199.21	1,796,800.79	57.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,052,000.00	2,411,199.35	-1,359,199.35	229.2
210205	Эрүүл мэндийн даатгал	10,520,000.00	9,643,699.40	876,300.60	91.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,389,000.00	38,092,784.43	296,215.57	99.23
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,956,539.63	43,460.37	98.55
210302	Түлш, халаалт	35,289,000.00	35,136,244.80	152,755.20	99.57
210303	Цэвэр, бэхир ус	100,000.00	-	100,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,714,000.00	29,138,533.00	575,467.00	98.06
210401	Бичиг хэрэг	5,520,000.00	5,374,400.00	145,600.00	97.36
210402	Тээвэр, шатахуун	20,900,000.00	20,900,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,044,033.00	355,967.00	85.17
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	894,000.00	820,100.00	73,900.00	91.73
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,964,496.00	35,504.00	99.41
210601	Багаж, тэхник, хэрэгсэл	3,000,000.00	2,962,096.00	37,904.00	98.74
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,002,400.00	-2,400.00	100.1
2107	Томилолт, зочны зардал	5,332,800.00	4,504,217.00	828,583.00	84.46
210702	Дотоод албан томилолт	5,332,800.00	4,504,217.00	828,583.00	84.46
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,416,000.00	3,714,250.00	1,701,750.00	68.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,400,000.00	2,811,500.00	588,500.00	82.69
210803	Даатгалын үйлчилгээ	760,000.00	462,750.00	297,250.00	60.89
210804	Тээврийн хэрэгслийн татвар	436,000.00	-	436,000.00	0.00

Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	-	180,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	440,000.00	10,000.00	97.78
210807	Газрын төлбөр	190,000.00	-	190,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,100,000.00	14,528,500.00	8,571,500.00	62.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,800,000.00	14,259,500.00	8,540,500.00	62.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	269,000.00	31,000.00	89.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,740,000.00	37,650,449.00	1,089,551.00	97.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,740,000.00	37,650,449.00	1,089,551.00	97.19
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,240,000.00	35,614,449.00	625,551.00	98.27
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,036,000.00	464,000.00	81.44
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,272,000.00	5,232,915.00	39,085.00	99.26
2200	Дотоод эх үүсвэрээр	5,272,000.00	5,232,915.00	39,085.00	99.26
223001	Бусад хөрөнгө	5,272,000.00	5,232,915.00	39,925,931.97	94.92
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	785,613,800.00	755,346,700.00	39,925,931.97	94.92
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	785,613,800.00	755,346,700.00	39,925,931.97	94.92
122005	Орон нутгийн төсвөөс	785,613,800.00	755,346,700.00	39,886,846.97	94.89
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	23	4	
620001	Удирдах ажилтан	7	6	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	-	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	
620004	Гэрээт ажилтан	6	3	3	

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	245,741,346.00	180,664,033.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,741,346.00	80,351,613.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,815,580.57	71,796,601.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	3,674,176.37
210301	Гэрэл, цахилгаан	-	3,674,176.37
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	15,317,800.00
210401	Бичиг хэрэг	-	348,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	14,969,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	224815580.57	52,804,625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,815,580.57	52,804,625.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,925,765.43	8,555,011.63
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,925,765.43	8,555,011.63
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	20,925,765.43	8,555,011.63
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	100,312,420.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	100,312,420.00
223001	Бусад хөрөнгө	-	100,312,420.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	245,741,346.00	180,664,033.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,741,346.00	180,664,033.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	245,741,346.00	180,664,033.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 117,182.7 мянган төгрөгийн 4 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа: **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын балансын хөрөнгөд бүртгэлтэй 2,500,0 мянган төгрөгийн зөврийн хогийн чиргүүлийг орлогоор тайлагнаагүй,
- Онцгой байдлын ерөнхий газраас 106,900.0 мянган төгрөгийн үнэ бүхий Jemnin маркийн 63-66 ГАҮ дугаартай авто тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд тусгаагүй,
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7,191.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй авснаар бүртгэсэн,
- Зам гүүрний элэгдлийн зардлыг программаар бүрэн бодуулаагүйгээс элэгдлийн зардал 591.6 мянган төгрөгөөр илүү тооцсон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 107,066.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 107,066.6 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрч 4,840.2 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 98,914.9 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 3,311.5 мянган төгрөгийн 2 заалт зөвлөмж хүргүүлээ.

Төлбөрийн акт

1. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас Олон улсын эмэгтэйчүүдийн баярт зориулан 1,073.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Байгууллагын удирдлагад 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдөр томилолтын зардлаас 320.0 мянган төгрөг олгосон ч томилолтын хуудаст ажилласан тухай тэмдэглэл байхгүй, ажлыг дүгнэж тооцоо хийхийг зөвшөөрч Засаг дарга баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

3. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 3 ажилтанд 389.2 мянган төгрөгийг илүү олгосон, урьдчилгаа цалингийн 1,930.0 мянган төгрөгийг дутуу суутгасан, Улирлын мөнгөн урамшууллыг олгохдоо тушаал шийдвэр гараагүй байхад 1 ажилтанд 528.0 мянган төгрөгийг олгож авлагаар тусгаагүй зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

4. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас сумын Засаг даргын шийдвэргүй 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Миний Алтай ХХК -д мэдээ, үйлчилгээний үнэнд 600.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 5 дугаар зүйлийн 5.3-т "Засаг даргын захирамжийг үндэслэн санхүү, төрийн сангийн нэгж

нөөц холбогдох арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгоно." гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс төрийн албан хаагч, малчдад зөвлөгөөн, сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулахад 3,463,7 мянган төгрөг, ахмадын баяр, санхүүчдийн баярыг тохиолдуулан 891.5 мянган төгрөг, хүндэтгэл үзүүлэхэд 3160,0 мянган төгрөг, батламжийн үнэнд 948,0 мянган төгрөг, нийт 8,463.2 мянган төгрөгийг үр дүнгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 5 дугаар зүйлийн 5.3-т "Засаг даргын захирамжийг үндэслэн санхүү, төрийн сангийн нэгж нөөц холбогдох арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг олгоно." гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Сумын 100 жилийн ойн дэмжлэгт олгосон санхүүжилтээс хүлээн авалтын болон бэлэг дурсгалын зүйл, хүнсний материал худалдан авахад 55,832.2 мянган төгрөг, ойн зохион байгуулалт хэрэгжилтийн тайлан хэвлүүлэн иргэдэд тараахад 7,200.0 мянган төгрөг, сумын наадам зохион байгуулахад 5,700.0 мянган төгрөг, улсын цол хүртсэн бөхийн шагналд 10,000.0 мянган төгрөг, үзэсгэлэнт газрын зураг авалт, зургийн үнэнд 4,291.0 мянган төгрөг, хэвлэлийн үнэнд 2,591.0 мянган төгрөг, цаг тооны бичгийн үнэнд 328.5 мянган төгрөг, сэлбэгийн зардалд 2,673.0 мянган, бусад урсгал зардал ажлын хөлс зэрэгт 2,164.5 мянган төгрөг, нийт 90,451.7 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг зориулалтын дагуу зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд харилцах данснаас бичиг хэргийн зардлыг 189.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлын 3,122.5 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2024 оны 229 дүгээр тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3.7.Тайлант үед хамаарах бараа, ажил үйлчилгээний зардлыг дансны өглөг ДТ, мөнгөн хөрөнгө КТ гэж бүртгэнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн данснаас аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлсэн зардлыг хоорондын тооцооны дансаар дамжуулан хөрөнгөд орлого авч зарцуулалтыг тайлагнахгүй шууд зардлаар бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, удирдлагаас нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Илрүүлэлт:

Тус байгууллага нь санхүүгийн тайланд авлагын 62,450.3 мянган, өглөгийн 75,585.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийг барагдуулж, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан, төрийн өмнөөс нөхөн төлбөрт төлсөн авлагыг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын ЗДТГ	4	117,182.7	2	109,400.0	2	7,782.7	4	117,182.7				
Дүн	4	117,182.7	2	109,400.0	2	7,782.7	4	117,182.7				

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дэлгэр сумын ЗДТГ	8	107,066.6	4	4,840.2	2	98,914.9	2	3,311.5	-	-	-	-
Дүн	8	107,066.6	4	4,840.2	2	98,914.9	2	3,311.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дэлгэр сумын ЗДТГ	1				1			
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дэлгэр сумын ЗДТГ								
Дүн								
-Нийт дүн	1	-			1	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

-----oOo-----